

ГЕПАТИТ, ЦУСАН СУУЛГА ӨВЧЛӨЛТИЙН ТҮВШИНГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Д.Гомбосүрэн, Говь-Алтай аймгийн Эрүүл
Мэндийн Газрын Халдварт Өвчний
Тандалт Судалгааны багийн ахлагч,
Анагаах ухааны доктор, /PhD/.

Та бүхэн энэхүү судалгаагаар Говь-Алтай аймгийн хүн амын дунд халдварт вирус гепатит болон цусан суулга өвчний тархалт, онцлого, хүн амын өвчлөлийн бүтцэнд сүүлийн 11 жилийн байдлаар тодорхойлон, шинжлэн судалсан бүтээлтэй танилцах болно.

Эдгээр халдварт өвчин нь ундны ус, хоол хүнсний хангамж, хүн амын ариун цэвэр, халдвар хамгаалал, орчны нөхцөл зэргээс ихээхэн шалтгаалдаг халдварт өвчин юм.

Хүн амын дунд ариун цэвэр эрүүл ахуй ба халдвар эсэргүүцэх, халдварын голомтыг эрт илрүүлэх, ариутгал, халдваргүйтгэлийг хийх, сургалт, сурталчилгаанд нийтийг идэвхитэй оролцуулах зэрэг урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг зохион байгуулснаар вирус гепатит болон цусан суулга зэрэг халдварт өвчнөөс бүрэн ангижрах боломжтой гэдгийг энэхүү судалгааны үр дүн харуулж байна.

Зорилго

Энэхүү ажил нь хүн амын өвчлөлөөс вирус гепатит, цусан суулга өвчний тохиолдлын түвшинг хөдөөгийн нөхцөлд судалж, нөлөөлөх хүчин зүйлийг ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэмтэй холбон дүгнэлт гаргах үндсэн зорилготой.

Судалгааны арга зүй, материал

Говь-Алтай аймгийн Эрүүл Мэндийн Газар Аймгийн Нэгдсэн Эмнэлэг, Нийгмийн Эрүүл Мэндийн Төвийн 1992-2002 онд бүртгэгдсэн вирус гепатит 2259 тохиолдол, цусан суулга өвчний 184 тохиолдлыг нас, хүйс, улирал, Алтай хот, сумын түвшингээр задлан судлав.

Судалгаанд эрүүл мэндийн бүртгэл, картуудаас, “халдварт өвчний голомтын халдвар судалгааны карт /ЭММ №10а, ЭМНХЯ, 1997-7-аар батлагдсан “яаралтай мэдээлэх хуудас”-уудыг ашиглав. Аймгийн Эрүүл Мэндийн Газрын Халдварт Өвчин Судлалын багт бүртгэгдсэн өвчлөл, сумдын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлэгчдийн яаралтай мэдээлэх хуудсыг түүвэрлэн, жил бүрийн тайлангийн материалтай жишиж үзэв.

Судалгааны үр дүн

Хүн амын өвчлөлийн бүтэц, вирус гепатит, цусан суулга өвчний сүүлийн 11 жилийн түвшинг тодорхойлсон зарим үзүүлэлтийг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Говь –Алтай аймгийн хүн амын дундах вирус гепатит, цусан суулга өвчний тархалт, сүүлийн 11 жилийн түвшнээр

Он	Вируст гепатит		Цусан суулга	
	Бодит тоо	10 000 хүн амд ногдох	Бодит тоо	10 000 хүн амд ногдох
1992	170	24.0	15	2.1
1993	91	12.7	30	4.2
1994	190	26.0	45	6.0
1995	227	31.1	19	2.5
1996	225	30.8	9	1.2
1997	145	20.6	24	3.4
1998	136	19.4	15	1.9
1999	97	13.8	12	1.7
2000	583	84.1	8	1.2
2001	192	28.8	3	0.4
2002	203	30.5	5	0.7
Дундаж	205.4	29.2	16.8	2.3

Эх сурвалж: Аймгийн Эрүүл Мэндийн Статистик, 2002

Энэхүү судалгаанаас үзэхэд, сүүлийн 11 жилийн /1992-2002/ дунджаар вирус гепатитын өвчлөлийн тохиолдол 205,4 бүртгэгдсэнээс 10000 хүн ам тутамд 29.2 ногдсон байна. Вирус гепатитын хамгийн бага өвчлөл нь 1993 онд 91 тохиолдол буюу 10000 хүн ам тутамд 12.7 болж буурсан нь сүүлийн 11 жилийн дунджаас 2.3 дахин бага байна. Харин 2000 онд тухайн өвчний өвчлөл нь 583 буюу 10000 хүн ам тутамд 84.1 тохиолдол бүртгэгдсэн нь дунджаас 2.9 дахин их байна.

Сүүлийн 11 жилийн хугацааны дунджаар цусан суулга өвчний өвчлөл 16.8 тохиолдол бүртгэгдсэнээс 10000 хүн амд 2.3 ногдож байна. Тухайн өвчний хамгийн бага тохиолдол 2001 онд 3 харин хамгийн их нь 1994 онд 45 тохиолдол бүртгэгджээ.

2000-2002 онд вирус гепатит өвчний тохиолдол 10000 хүн ам тутамд 28.8-84.1 болж өсөн нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэм суларч, хүн амын эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хангалтгүй, нөгөө талаас хөдөөгийн хүн амын ядуурал, зуд, байгалийн гамшгийн нөлөөнд нэрвэгдэн амьдралын түвшин доошилж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Харин цусан суулга өвчин сүүлийн 3 жилийн байдлаар 10000 хүн амд 0.4-1.2 болж буурсан үзүүлэлт гарч байгаа нь бусад суулгат халдвараас ялган салгаж, оношлох үйл ажиллагаатай холбоотойгоор багассан мэт харагдаж байгааг үгүйсгэхгүй.

Ер нь халдварт өвчнийг бууруулах, хүн амын ариун цэврийн түвшинг дээшлүүлэх, халдварын голомт болон албан газар, сургууль, цэцэрлэг, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, борлуулдаг цэг салбаруудад урьдчилан сэргийлэх ариутгал, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл, халдваргүйтгэлийг заавар, журмаар хийдэг ажил үндсэндээ орхигджээ.

Хүснэгт 2. Говь-Алтай аймгийн хүн амын дундах вирус гепатит, цусан суулгын өвчлөл, улирлаар, 1992-1997, 1998-2002 оноор

Улирал	Вируст гепатит		Цусан суулга	
	1992-1997 он	1998-2002 он	1992-1997 он	1998-2002 он
I	21.5	20.4	28.9	30.9
II	22.9	18.1	40.1	26.3
III	19.5	17.4	6.5	11.9
IV	36.1	44.1	24.5	30.9
Дүн	100	100	100	100
Тоо	1048	1211	142	42

Эх сурвалж: Аймгийн Эрүүл Мэндийн Статистик, 2002

Хүснэгт 2-оос үзэхэд IV-р улиралд вирус гепатитын өвчлөлийн тохиолдол хамгийн өндөр түвшинд байгааг харж болно.

Вируст гепатитын өвчлөл нь хүйтэн сэрүүний улиралд өндөр байгаа явдал хүн ам олноор бөөгнөрч суурьших, нөгөө талаас хүнсний ногоо, жимс жимсгэнийг дотоод болон гадаад орнуудаас зөөвөрлөн хүнсэндээ хэрэглэхдээ эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг зөрчих, ариун цэврийн дэглэмийг алдагдуулах, хүнсэнд хэрэглэх зэрэгтэй тодорхой хэмжээгээр холбоотой юм.

Урин дулааны улиралд цусан суулгын өвчлөл нэмэгддэг явдал нь хүнсний аюулгүй байдал, гэдэсний халдварыг дамжуулан тараагч ялаа батгана, хог хаягдал, бохир орчинд ахуйн хортон шавьж өсөн үржих, ундны усны ариун цэвэр, эрүүл ахуй, халдвар хамгааллын аюулгүйн журам зөрчигдөж, усыг түүхийгээр уух зэрэг ахуйн дадалтай холбоотой байна.

Хүснэгт 3. Вируст гепатит, цусан суулгын өвчлөл, ажил эрхлэлтийн байдлаар, 1992-1997; 1998-2002 оноор

Ажил эрхлэлт	Вируст гепатит		Цусан суулга	
	1992-1997 он	1998-2002 он	1992-1997 он	1998-2002 он
Ажилчин	4.5	1.7	5.6	2.4
Малчин	7.8	7.3	11.3	21.4
Албан хаагч	6.0	2.6	1.4	7.1
Оюутан	1.3	2.1	1.4	-
Цэц, яслын насныхан	10.1	16.8	7.1	7.1
Ясли	4.2	0.4	3.0	-
Гэртээ байдаг хүүхэд	39.3	36.5	46.0	45.2
Ажилгүй	13.5	7.7	15.5	7.1
Дүн	100	100	100	100
Тоо	1048	1211	142	42

Эх сурвалж: Аймгийн Эрүүл Мэндийн Статистик, 2002

Вируст гепатитаар өвчлөгсдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл, 1992-1997 онд 39.3 хувийг гэртээ хүмүүжиж бойжиж байдаг хүүхэд, 13.5 хувийг нь ажилгүйчүүд эзэлж байв. Харин 1998-2002 оны хувьд ажилгүйчүүдийн өвчлөл 5.8 пунктээр буурсан байна. Вируст гепатит болон цусан суулгат өвчин голдуу бага насны хүүхдэд илүүтэй тохиолдож байгааг Хүснэгт 3-ийн үр дүн харуулж байна. Бага насны

хүүхдийн дунд вируст гепатит, цусан суулга өвчний тохиолдол их байгаа нь тэдний биеийн онцлог, ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм сахихтай холбоотой юм.

1999-2002 онд вируст гепатитын өвчлөлийн тохиолдол Алтай хотод 1644, сумуудад 615, цусан суулга өвчний өвчлөл Алтай хотод 149, сумуудад 35 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Бодлогын зөвлөмж

- Халдварт вируст гепатитын өвчлөл 1992-2002 оны хооронд Говь-Алтай аймагт 2.9 дахин нэмэгдсэн байна.
- Бага насны хүүхдүүдийн дунд цусан суулга өвчнөөр өвчлөгчдийн хувь хамгийн өндөр байна.
- Вируст гепатитын хор хөнөөлийг тайлбарлах нь эцсийн эцэст элэг цэсний архаг үрэвсэлтэй болж, элэг хатуурах, өмөн үүсгэхийн үндэс болдог талаар олонхи судлаачдын дүгнэлтэнд тулгуурлан цаашид судалгааг нарийсган явуулах шаардлагатай байна.

Ном зүй

1. Е.Л.Баткис. Учебное пособие по медицинской статистики. Л, 1972, стр 42-55.
2. Я.Дагвадорж, Б.Баярмагнай, Б.Байгаль, Д.Наранцэцэг, Д.Долгор. Монгол дахь E вируст гепатитыг судлах асуудалд “Урьдчилан сэргийлэх анагаах ухааны асуудлууд” 1998, Улаанбаатар, хуудас 49.
3. Т.Дэлгэр, Б.Байгаль, Т.Аира, С.Ананд. “Гэдэсний халдварт өвчний бүтэц” Халдварт өвчний тулгамдсан асуудлууд, 1999, Улаанбаатар, хуудас 24-26.
4. П.Нямдаваа, Х.Цацрал, Т.Оюунбат, О.Энхбат, Ш.Янжмаа, Ж.Оюунбилэг. “Насанд хүрсэн эрүүл монгол эрчүүдэд B вируст гепатитын маркеруудын тархалтыг судалсан дүн, “Урьдчилан сэргийлэх анагаах ухааны асуудлууд”, 1998, Улаанбаатар, хуудас 50.
5. В.И.Покровский, Н.Д.Юшук. “Этиология, эпидемиология, патогенез дезинтерия”, 1994, Москва, стр 6-35.